

## ӨГҮҮЛЭЛ

# Нарендра Модигийн үеийн Энэтхэгийн гадаад бодлого дахь Монгол Улс

Энхбаатарын Мөнхзул 

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,  
Улаанбаатар, Монгол Улс  
munkhzul\_e@mas.ac.mn

**Хураангуй:** Олон жилийн турш Энэтхэгийн Үндэсний Конгрессын нам засгийн газрыг тэргүүлж байсан явдлыг халж 2014 онд Бхарати Жаната нам сонгуульд ялсан нь Энэтхэгийн гадаад бодлого хэрхэн өөрчлөгдөж, хаашаа чиглэх нь олон улсын харилцаа, улс төр судлаачдын анхаарлыг татаж байв. Н.Модигийн удирдлагад ишлэсэнээр Энэтхэгийн гадаад бодлого эрс өөрчлөгдөнө, эсвэл өмнөх үеийн бодлогыг үргэлжлүүлэн авч явна гэж судлаачид хоёр талд хуваагдаад байсан юм. Н.Моди Энэтхэгийн гадаад бодлогыг бүс нутагтаа төдийгүй дэлхийд хүчирхэг гүрэн болох байр суурь руу чиглэсэн эдийн засгийн дипломат ажиллагаа, хүчтэй гадаад бодлогыг гарган ирж явуулах болжээ.

**Түлхүүр үгс:** Нарендра Модиг, Энэтхэгийн гадаад бодлого, ашиг сонирхол, Монгол Улс, Гуравдагч хөршийн бодлого

### Удиртгал

Энэтхэг Улс нь 1947 оны 8 дугаар сарын 15-нд тусгаар тогтнолоо зарлан, үндсэн хуулиа баталж, парламентын засаглалтай, дэлхийн хамгийн том ардчилсан орон болсноор тус улс нээлттэй гадаад бодлого явуулж эхэлсэн. Тухайн үеийн Энэтхэгийн Үндэсний Конгрессын намын тэргүүлэгч, тусгаар тогтнолын төлөөх тэмцэгчдийн нэг Жавахарлал Неру Энэтхэгийн гадаад бодлогын суурийг тавьсан. Ж.Неру

Махатма Гандигийн хамт эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг өрнүүлж, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг боловсруулан, гадаад бодлогоо явуулах болов. Энэ нь Энэтхэг Улсын өнөөгийн олон улсын харилцаан дахь байр суурь, дүр төрхийг бүтээхэд гол суурь нь болсон юм.

Олон жилийн турш Энэтхэгийн Үндэсний Конгрессын нам засгийн



газрыг тэргүүлж байсан явдлыг халж 2014 онд Бхарати Жаната нам сонгуульд ялсан нь Энэтхэгийн гадаад бодлого хэрхэн өөрчлөгдөж, хаашаа чиглэх нь олон улсын харилцаа, улс төр судлаачдын анхаарлыг татаж байв. Н.Модигийн удирдлагад шилжсэнээр Энэтхэгийн гадаад бодлого эрс өөрчлөгдөнө эсвэл өмнөх үеийн бодлогыг үргэлжлүүлэн авч явна гэж судлаачид хоёр талд хуваагдаад байсан юм. Н.Моди Энэтхэгийн гадаад бодлогыг бүс нутагтаа төдийгүй дэлхийд хүчирхэг гүрэн болох байр суурь руу чиглэсэн эдийн засгийн

дипломат ажиллагаа, хүчтэй гадаад бодлогыг гарган ирж явуулах болсноор Энэтхэгийн гадаад бодлогын шинэ өөрчлөлт “Модигийн номлол”-оор гарч ирлээ гэж судлаачид<sup>1</sup> үзэх болов. Энэ өгүүллийн хүрээнд 2014-2024 он хүртэлх хугацаанд Н.Модигийн гадаад бодлого буюу Энэтхэг Улсын гадаад бодлогын онцлогийг судлан тодорхойлох мөн Монгол Улс Энэтхэг Улсын гадаад бодлогод ямар байр суурь эзэлж байгаа болон Энэтхэгийн ашиг сонирхол байна уу? гэдгийг судлан харуулахыг зорилоо.

### Нэг. Нарендра Модигийн гадаад бодлого (2014 оноос өнөөг хүртэл)

2014 оны БНЭУ-ын парламентын доод танхимын сонгууль нь олон талаараа онцлогтой, Энэтхэгийн Улс төрийн түүхэнд чухал үйл явдал болон тэмдэглэгдсэн. Учир нь Энэтхэгийн ардчиллын түүхэнд засгийн эрхийг олон жилийн турш барьсан Үндэсний Конгрессын нам бус Бхарати Жаната нам дангаараа парламентын олонхыг бүрдүүлж, ялалт байгуулсан юм. Энэхүү сонгууль нь сонгогчдын оролцооны хувьд түүхэн дээд хэмжээнд хүрсэн бөгөөд ирц нь 66.4%, сонгогчдын тоо 834 сая байжээ.<sup>2</sup> 2014 оны 5 дугаар сард Н.Моди БНЭУ-ын Ерөнхий сайд болж анхны бүрэн эрхийн хугацаандаа өмнөх Ерөнхий сайд Манмохан Сингхийн арван жилийн хугацаанд хийсэн гадаад айлчлалуудтай дүйцэхүйц хэмжээний олон айлчлалыг гадаад улс орнуудад хийж, өндөр, дээд

түвшний олон чуулга уулзалтад оролцсон юм. Түүнчлэн БНХАУ, Япон, АНУ болон Өмнөд Ази даяарх түншүүдтэйгээ харилцаа холбоогоо бэхжүүлэхийг зорьж гадаад бодлогоо идэвхтэй явуулж эхэлсэн. Н.Модигийн Засгийн газар Энэтхэгийн далайн бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ, Ойрх Дорнодоос Төв Ази болон Өмнөд Азиас Зүүн Өмнөд Ази хүртэлх улс орнуудтай батлан хамгаалах, дипломат харилцаагаа сайжруулах зорилготой байгаагаа мэдэгдсэн. Түүнчлэн Модигийн Засгийн газар Энэтхэгийн гадаад бодлогыг уламжлалт зарчимд нийцүүлэн, илүү боловсронгуй болгон хөгжүүлэхээ хэлж, Энэтхэгийн дэлхийд эзлэх байр суурь, эрх ашгийг АНУ, БНХАУ зэрэг том гүрнүүдэд хүлээн зөвшөөрүүлж,

<sup>1</sup> Chellaney, Bramha, “Deconstructing the Modi Foreign Policy.” Hindu, The Hindu, December 4, 2021  
Chaulia, Sreeram, Modi Doctrine The Foreign Policy of India’s Prime Minister, 2016

<sup>2</sup> Louise Tillin, Indian elections 2014: explaining the landslide, *Contemporary South Asia*, 5 May 2015, p-117

баталгаажуулахыг зорьсон.<sup>3</sup>

Судлаачдын үзэж байгаагаар Энэтхэг олон улсын харилцаанд идэвхтэй оролцогч болон гарч ирж байгаа нь тус улсыг дэлхийн тавцанд илүү их үүрэг гүйцэтгэх, манлайллын шинэ боломжийг эрэлхийлж байна<sup>4</sup> хэмээн үзжээ.

Өнөөгийн Энэтхэгийн гадаад бодлогыг олон улсын харилцааны онолын үүднээс хүчний тэнцвэрийн онол, реализмын онолоор тайлбарлаж болно. Энэтхэг Улс олон улсын харилцаанд прагматик хандлагатай бөгөөд үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил, болон өөрийн стратегийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавьдаг. Энэхүү стратегийн бие даасан байдал, олон улсын харилцаанд өөрийн хүч, нөлөөг нэмэгдүүлэхийг зорьж байгаа нь олон улсын харилцааны реализмын онолоор<sup>5</sup> тайлбарлаж болно.

Реалистуудын үзэж буйгаар олон улсын тавцан гэдэг нь аливаа улсуудын хувьд өөрсдийн нөлөө, хүч чадлаа нэмэгдүүлэхийн төлөөх “Мөнхийн тэмцлийн” талбар гэж тодорхойлжээ.<sup>6</sup> БНЭУ-ын гадаад бодлогын гол зорилго нь үндэсний ашиг сонирхлоо нэн тэргүүнд тавьж өөрсдийн аюулгүй байдлаа хангах үүднээс цэргийн хүч, эдийн засгийн хүчээ нэмэгдүүлэх буюу

тэрхүү реализмын онолын үндсэн зарчим хүчний тухай ойлголт ялангуяа “hard power”-ыг чухалчилж буйд нийцэлтэй байна.

Энэтхэг Улс нь бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд өөрийн стратегийг “хүчний тэнцвэр”-ийг бий болгох гэж тодорхойлж, хөрш орнуудтайгаа болон их гүрнүүдтэй тогтвортой харилцаа явуулахыг эрмэлздэг. Олон улсын харилцааны реализмын онолын төлөөлөгчдийн нэг Э.Х.Карр прагматик үзлийг дэмждэг бөгөөд үндсэндээ олон улсын харилцааг хүч, ашиг сонирхол, улс төрийн бодлогоор тайлбарлахыг зорьдог. Өөрөөр хэлбэл олон улсын харилцаанд бодит байдал болон ашиг сонирхлыг хамгийн чухал гэж үздэг. Энэтхэг Улс олон улсын харилцаанд прагматик хандлагатай бөгөөд хамгийн чухал нь үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил, болон өөрийн стратегийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьдаг түүнчлэн олон улсын харилцаанд өөрийн хүч, нөлөөг өсгөхийг зорьж буй<sup>7</sup> нь Каррын онолын үзэл баримтлалтай нийцэж байна. Энэтхэг Улс олон улсын байгууллага, бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны хүрээнд идэвхтэй оролцохын зэрэгцээ, үндэсний аюулгүй байдал болон стратегийн түншлэлд

<sup>3</sup> Ian Hall, Summit Ganguly, Introduction: Narendra Modi and India's foreign policy, *International Politics*, 2022, p-3

<sup>4</sup> Chaulia, Sreeram, Modi Doctrine: The Foreign Policy of India's Prime Minister, 2016

<sup>5</sup> Aneetta Thomas Peedikayil, Aswathy Koonampilly, Medha Bhagwat, India's Realist Foreign Policy: Present-Day Relevance, Extraordinary and Plenipotentiary Diplomats Analysing International Relations, 20 October, 2020 <https://diplomatist.com/2020/10/20/indias-realist-foreign-policy-present-day-relevance/>

<sup>6</sup> Дэмбэрэл.К, *Олон улсын харилцааны онол, үйл ажиллагааны үндэс*, Улаанбаатар, 2018 он

<sup>7</sup> Aneetta Thomas Peedikayil, Aswathy Koonampilly, Medha Bhagwat, India's Realist Foreign Policy: Present-Day Relevance, Extraordinary and Plenipotentiary Diplomats Analysing International Relations, 20 October, 2020 <https://diplomatist.com/2020/10/20/indias-realist-foreign-policy-present-day-relevance/>

ИХЭЭХЭН АЧ ХОЛБОГДОЛ ӨГЧ БАЙНА.<sup>8</sup>

	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
BIMSTEC											
BRICS											
CHOGM											
EAS-ASEAN											
FIPIC											
G-7											
G-20											
IEUS											
QUAD											
SAARC											
SCO											
UNFCCC											

Зураг 1. Ерөнхий сайд Нарендра Модигийн оролцсон бүс нутаг, олон талт хамтын ажиллагааны байгууллага, форумын уулзалт

Эх сурвалж: <https://www.pmindia.gov.in/en/>

Энэтхэгийн дипломатч, судлаач Ачал Малхотрагийн хэлснээр<sup>9</sup> Н.Модигийн үеийн Энэтхэгийн гадаад бодлогын нэг онцлог нь тив дамнан жижиг, дунд, том улсуудыг хамарсан урьд өмнө байгаагүй улс төр, дипломатын харилцааг идэвхтэй явуулсанд байгаа

юм. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Дэд Ерөнхийлөгч, Гадаад харилцааны сайд, бусад сайд нарын түвшинд өндөр, дээд хэмжээний айлчлал их өрнөсөн нь өмнөх үеийн сайдтай харьцуулбал өндөр байна.

Хүснэгт.1 Ерөнхий сайд байсан Манмохан Сингх болон одоогийн Ерөнхий сайд Нарендра Модигийн гадаад улс оронд хийсэн айлчлалын тоо

Ерөнхий сайд, он	Айлчилсан орнууд							нийт
	БНХАУ	Пакистан	АНУ	Орос	АСЕАН-ны орнууд	Монгол	Бусад	
Ма.Сингх (2004-2014)	2008, 2013		2005, 2009	2005 2007 2009 2011 2013	2004 2010 2011 2012 2013-2		21	36

<sup>8</sup> Мөн тэнд

<sup>9</sup> Achal Malhotra, India's Foreign Policy: 2014-19: Landmarks, achievements and challenges ahead, <https://www.mea.gov.in/distinguished-lectures-detail.htm?833>

Н.Моди (2014-2024)	2015	2015	2014	2014	2015 2016 2017 2018 2019 2018-3	2015	54	78
	2016		2016	2015				
	2018		2017	2017				
	2019		2021	2018				
			2023	2019				
			2024	2024				

Эх сурвалж: <https://www.pmindia.gov.in/en/pm-visits/page/8/>

Н.Модигийн хэрэгжүүлж буй гадаад бодлогыг дараах байдлаар тодорхойлж болно.

*Хөрш орнууд руу чиглэсэн бодлого<sup>10</sup>:*

2014 онд Н.Модигийн засгийн газар ажлаа авснаар хамгийн эхэнд хөрш зэргэлдээ улс орнууд (Афганистан, Бангладеш, Бутан, БНХАУ, Мальдив, Мьянмар, Непал, Пакистан, Шри-Ланка, Индонези) руу чиглэсэн бодлогоо эрчимжүүлэх, олон нийтэд таниулах явдал байсан юм. Тус бодлого нь хөрш орнуудтай харилцах харилцааны түвшингээ ахиулах, бэхжүүлэх, бүс нутагт энх тайван тогтвортой байдал, хамтын ажиллагааны хөгжил дэвшлийг бий болгохыг зорьдог байна. Энэ бодлого нь Энэтхэгийн Засгийн газрын харьяа холбогдох байгууллагуудын тэргүүлэх чиглэл<sup>11</sup> болон төлөвшсөн. Энэ бодлогын нэн тэргүүнд БНХАУ, Пакистан Улсуудыг авч үздэг. Тус орнуудтай газар нутгийн маргаанаас үүдэлтэй асуудал олон жилийн турш үргэлжилж байгаа нь Энэтхэгийн газар нутгийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал, ашиг сонирхлын асуудлыг хөндөж байдаг учир тогтвортой, тэнцвэртэй харилцаа бий болгохыг эрхэмлэдэг байна.

*БНХАУ-тай харилцах харилцаа:* Энэтхэгийн Хятад руу чиглэсэн бодлого

нь эдийн засгийн хамтын ажиллагаа, стратегийн өрсөлдөөнийг хослуулсан цогц бодлого юм. Энэтхэгийн гадаад бодлогын хувьд Хятад Улс нь Зүүн Хойд Азийн бүс нутагт стратегийн өндөр ач холбогдолтой, чухал байр суурийг эзэлдэг бөгөөд өрсөлдөгч, түншийн харилцаа аль алиныг нь тодорхойлдог. Эдийн засгийн талаас Хятад Улс Энэтхэгийн эдийн засгийн худалдааны гол түнш төдийгүй Digital India, Start-up India зэрэг олон санаачилгуудад хувь нэмэр оруулан дэмжин ажиллаж байна. Н.Моди БНХАУ-ыг эдийн засгийн хувьд ялангуяа худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт татан оролцуулан хамтын ажиллагаагаа хөгжүүлэх эрмэлзэлтэй боловч хилийн маргааны асуудал нь саад учруулсаар байв. 2017 онд Бутаны ойролцоох Энэтхэг, Хятадын цэргүүдийн хооронд үүссэн Докламын мөргөлдөөн байдлыг улам хурцатгасан боловч эцэст нь дипломат шугамаар шийдэгджээ.

Энэтхэг Хятадтай худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны боломжоо ашиглан харилцаж байгаа хэдий ч аюулгүй байдлын үүднээс геополитикийн нөхцөл, түүхэн ээдрээтэй байдлыг харгалзан үзвэл энэ харилцаандаа болгоомжлонгуй ханддаг.<sup>12</sup> БНЭУ-БНХАУ нь улс төр,

<sup>10</sup> Англиар Neighbourhood First Policy

<sup>11</sup> India's Foreign Policy: 2014-19: Landmarks, achievements and challenges ahead, Ministry of External Affairs, Government of India, 2 July 2019, <https://www.mea.gov.in/distinguished-lectures-detail.htm?833>

<sup>12</sup> Wooyeal Pak, Rajiv Kumar. (2019 оны April 30). India's Extended "Act East" Outreach to Northeast

дипломатын харилцаа, эдийн засгийн харилцааны хувьд найрсаг харилцаатай боловч олон жил үргэлжилсэн хилийн маргаанаа шийдвэрлэж чадаагүй ирсэн. Энэ асуудлыг аль аль талдаа ашигтай байхаар тохиролцон зохицуулахыг хичээж байгаа талаар БНЭУ-ын ГХЯ-ны нарийн бичгийн дарга Викрам Мисри БРИКС-ийн уулзалтын өмнөхөн мэдэгдсэн юм. 2024 оны 10 дугаар сарын 22-24-ны хооронд ОХУ-ын Казань хотноо болсон БРИКС-ийн удирдагчдын дээд хэмжээний уулзалтаар Ерөнхий сайд Нарендра Модри, БНХАУ-ын дарга Ши Жиньпин нар хоёр талын уулзалт хийж хилийн асуудлыг нааштайгаар шийдвэрлэхээр ярилцаж тохиролцоод байна.

Хэдийгээр хоёр улс түүхэн, урт хугацааны туршид ийн маргаантай байсаар ирсэн асуудлаа сүүлийн жилүүдэд хүчин чармайлт гарган шийдвэрлэхийг хичээж байгаа нь цаашдын харилцаа илүү хөгжих боломжийг бий болгож байна. Энэтхэгийн хөрш орнууд руу явуулж буй гадаад бодлого нь дипломат ажиллагаа явуулах, буулт хийх зэрэг тэнцвэртэй бодлого явуулж буй нь олон улстай харилцах харилцаанд гарч ирж буй сорилтуудыг шийдвэрлэхэд нэн чухал гэсэн реализмын онолын Э.Х.Каррын үзэл санаатай нийцэж байна.<sup>13</sup> Энэтхэг Улс бусад орнуудтай харилцан ашигтай харилцаж эдийн засгаа хөгжүүлэх замаар БНХАУ-ын Ази дахь нөлөөг тэнцвэржүүлэн барихыг оролдох

буюу олон улсын харилцаанд хүчний тэнцвэрийг бий болгохыг эрмэлзэж байна.

*Их гурнуудтэй харилцах харилцаа:*

*АНУ-тай харилцах харилцаа:* БНЭУ, АНУ нь ардчиллын нийтлэг үнэт зүйлс, бүс нутгийн болон дэлхийн хэмжээний асуудлуудад ашиг сонирхлын нэгдмэл байдал, ард түмэн хоорондын найрсаг, ойр харилцаанд тулгуурлан бүх салбарыг хамарсан “Дэлхийн стратегийн иж бүрэн түншлэл”-ийн харилцаатай улсууд юм. Удирдагч нарын тогтмол яриа хэлэлцээ нь хоёр талын харилцаа өргөжин тэлэх чухал хүчин зүйл төдийгүй айлчлалын үр дүн нь хоёр талын олон талт харилцааг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.<sup>14</sup> Н.Модри Ерөнхий сайд болж идэвхтэй гадаад бодлого явуулах болсноор түүний үеэс АНУ-тай харилцах харилцаа идэвхжиж эхэлсэн гэж хэлж болно.

Н.Модри Ерөнхий сайд болмогцоо 2014 оны 9 дүгээр сард АНУ-д айлчилсан. Харин үүний дараахан 2015 оны 1 дүгээр сарын 26-ны Энэтхэгийн Бүгд Найрамдах баярын өдрийг тохиолдуулан Ерөнхий сайд Н.Модигийн урилгаар АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамаг хариу айлчлал хийсэн нь тус хоёр улсын харилцаа сайжирч байгаагийн илрэл болов. Айлчлалын үеэр хоёр тал Делигийн найрамдлын тунхаглалыг гаргаж, Ази Номхон далай, Энэтхэгийн далайн бүс нутгийн стратегийн хамтарсан үзэл баримтлалыг баталсан.

Asia: Its Economic and Security Interactions with China, Japan, and South Korea, *The Korean Journal of International Studies*, 1-29. doi:<https://doi.org/10.14731/kjis.2019.4.17.1.1>

<sup>13</sup>

<sup>14</sup> India-US Bilateral Relations, Ministry of External Affairs of India, October 9, 2023 [https://www.mea.gov.in/Portal/ForeignRelation/Bilateral Brief as on 09.10.2023.pdf](https://www.mea.gov.in/Portal/ForeignRelation/Bilateral%20Brief%20as%20on%2009.10.2023.pdf)

Үүнээс хойш хоёр улсын хооронд өндөр, дээд хэмжээний айлчлал, уулзалтууд ихээр өрнөх болов. Н.Моди, Барак Обамагийн үеийн хоёр улсын харилцаа батлан хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн асуудлаар илүү хүчтэй хамтын ажиллагааг явуулах үндэс суурийг тавьсан. АНУ-Энэтхэгийн Батлан хамгаалах технологи, худалдааны санаачилгын (ДТТ) хүрээнд Н.Модигийн засгийн газар хамтарсан цэргийн сургуулилт, батлан хамгаалахын борлуулалт зэрэг батлан хамгаалах салбарын харилцаагаа гүнзгийрүүлэхээр ажиллаж байв. Энэтхэг мөн Батлан хамгаалахын гол түнш статусыг авсан нь батлан хамгаалахын үйлдвэрлэл, технологи солилцох чиглэлээр илүү нягт хамтран ажиллах боломжийг олгосон юм.

Доналд Трампын Засгийн газрын үед Н.Моди АНУ-тай харилцах дипломат арга барилаа нийцүүлэн худалдаа, терроризмын эсрэг хүчин чармайлт, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх ялангуяа аюулгүй байдлын хамтын ажиллагаа, Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагаанд анхаарлаа хандуулах болжээ.<sup>15</sup> Жо Байдэны засаг захиргааны үед хоёр улс уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн эрүүл мэндийн асуудал, батлан хамгаалах салбар зэрэг дээр анхааран харилцаа, хамтын ажиллагаа өрнөж байв. Н.Моди Энэтхэг-Номхон далай дахь Энэтхэгийн гүйцэтгэх үүргийг үргэлжлүүлэн

дэмжиж, аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэж<sup>16</sup> байна. Н.Модигийн АНУ-руу чиглэсэн бодлого нь гурван өөр удирдагчийн үетэй нүүр тулсан ч удирдлагын өөрчлөлтөд хурдан дасан зохицож харилцаагаа үргэлжлүүлэн явуулж байна.

АНУ, Энэтхэгийг НАТО-гийн холбоотнуудтай эн зэрэгцүүлэн өндөр ач холбогдолтой гэж харах болов. АНУ-ын тэргүүлэх чиглэлд Энэтхэгийг Ази дахь Хятадын нөлөөг тэнцвэржүүлэх боломж гэж үзэж байгаад<sup>17</sup> оршино. Тэр ч утгаараа АНУ, БНЭУ-тай Дөрвөн талт, аюулгүй байдлын хамтын ажиллагааны хүрээнд харилцах сонирхол, ач холбогдол өндөр бий. 2007 онд Японы ерөнхий сайд Шинзо Абэгийн санаачилгаар АНУ, Энэтхэг, Япон, Австрали улсуудын хооронд анх энэ санаачилга эхэлсэн ч төдийлөн идэвхтэй байгаагүй юм. Харин АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампын засаглалын үед буюу 2017 оноос энэ санаачилга хүчээ авч, дахин сэргэж эхэлсэн бөгөөд АНУ Энэтхэг-Номхон далайн бүс нутагт далайн аюулгүй байдал, гамшгийн менежментийг хангахад Энэтхэгтэй хамтран ажиллахыг эрмэлздэг. Ялангуяа Энэтхэг-Номхон далайн бүс нутаг, Өмнөд Хятадын тэнгис дэх Хятадын нөлөөг хязгаарлах зорилготой юм.

QUAD нь 2007 онд анх байгуулагдаж, 2017 онд дахин сэргэснээс хойш Энэтхэгийн энэ бүлэг

<sup>15</sup> Joint Statement: Vision and Principles for India-U.S. Comprehensive Global Strategic Partnership, Ministry of External Affairs Government of India, February 25, 2020

<sup>16</sup> Мөн тэнд

<sup>17</sup> Ian Hall, Summit Ganguly. (2022 оны October 30). Introduction: Narendra Modi and India's foreign policy. *International Politics*, p-3. <https://link.springer.com/article/10.1057/s41311-021-00363-8>

дэх үүргийн талаар маргаан судлаачдын дунд байсаар ирсэн. Учир нь энэ бүлэг дэх батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхээс зайлсхийж буй Энэтхэгийн байр сууриас үүдэлтэй юм. Гэвч 2017, 2020 онд болсон Энэтхэг, Хятадын хилийн мөргөлдөөн нь Энэтхэгийн талаас QUAD-ыг илүү хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн үйл явдал болов. Хятадын Энэтхэг-Номхон далайн бүсэд өсөж буй нөлөө нь QUAD-ын бүх гишүүдэд сорилт болж байгаа хэдий ч Энэтхэг QUAD-ыг Хятадын эсрэг бүлгэм гэж харахыг хүсдэггүй. Үүний оронд QUAD нь “Хэн нэгний эсрэг биш, харин ямар нэгэн зүйлийн төлөө зогсож буй” бүлгэм гэж тодорхойлж хардаг байна. QUAD нь Энэтхэгийн хувьд цэргийн холбооноос илүүтэйгээр зөвлөлдөх механизмаар бүс нутагт байр суурь, нөлөөгөө хадгалах боломжийг олгодог.<sup>18</sup>

Энэтхэгийн QUAD дахь ашиг сонирхол нь дараах хэдэн байдлаар илэрнэ.

- Энэтхэг нь бүс нутгийн аюулгүй байдлыг дан ганцаараа шийдвэрлэх боломжгүй тул энэ бүс дэх ижил ашиг сонирхол, үзэл хандлагатай улсуудтай хамтран Энэтхэг-Номхон далайн бүс нутагт эдийн засаг, аюулгүй байдлын хамтын ажиллагаагаа явуулах сонирхолтой.
- QUAD нь Энэтхэгт АСЕАН-ы

орнуудтай харилцаагаа хөгжүүлэх боломжийг олгодог бөгөөд үүнийгээ Хятадын эсрэг сөргөлдөөнийг нэмэгдүүлэхгүйгээр харилцаа, хамтын ажиллагаагаа явуулахыг эрмэлздэг байна.

Энэтхэг Улс дэлхийн олон туйлт системд гуравдагч гол хүч болон гарч ирж буйн хувьд АНУ, Хятад зэрэг хүчирхэг улсуудын дунд хүчний тэнцвэрийг тогтоох үйл явцад чухал байр суурь, нөлөөтэй тоглогч болж байна.

*ОХУ-тай харилцах харилцаа:* Энэтхэг Улс тусгаар тогтнолоо олсны дараа эхэн үедээ цэргийн хүчин чадалд төдийлөн ач холбогдол өгдөггүй байсан ч хөрш зэргэлдээ орнуудтай газар нутгийн маргаан, бүс нутаг дахь цөмийн зэвсгийн тархалт зэрэг асуудлаас үүдэн гадаад бодлогоо эргэн харж, өөрсдийн үндэсний аюулгүй байдалд анхаарлаа төвлөрүүлэн, бодитой арга барилыг нэвтрүүлэхэд хүргэсэн гэж реалистууд үздэг байна.<sup>19</sup>


Энэтхэг хөрш улсуудтайгаа газар нутгийн маргаанаас үүдэлтэй гадаад аюулгүй байдлын асуудал ихээр хөндөгддөг учир хүйтэн дайны үеэс эхлэн тухайн үеийн хүчирхэг гүрний нэг болох ЗХУ-тай харилцаагаа ойртуулж эхэлсэн байна. Орос, Энэтхэгийн найдвартай түнш байсаар ирсэн ба Энэтхэгийн гадаад бодлогын гол

<sup>18</sup> Aditi Malhotra, Engagement, not Entanglement: India's Relationship with the Quad, *Georgetown Journal of International Affairs*, May 1 2023, <https://gja.georgetown.edu/2023/05/01/engagement-not-entanglement-indias-relationship-with-the-quad/>

<sup>19</sup> Aneetta Thomas Peedikayil, Aswathy Koonampilly, Medha Bhagwat, India's Realist Foreign Policy: Present-Day Relevance, Extraordinary and Plenipotentiary Diplomats Analysing International Relations, 20 October, 2020 <https://diplomatist.com/2020/10/20/indias-realist-foreign-policy-present-day-relevance/>



FIGURE 4  
Indian Arms Imports From Top 5 Suppliers, 1992-2021



SOURCE: SIPRI Arms Transfer Database, accessed July 27, 2022.

NOTE: TIVs, or trend indicator values, are based on the known unit production costs of a core set of weapons. SIPRI intends to capture all military resources rather than a transfer's financial value.


## Зураг 2. Энэтхэгийн зэвсгийн импорт, улсаар, (1992-2020)

Эх сурвалж: <https://www.sipri.org/databases/armstransfers>

тулгуур баганын нэг<sup>20</sup> бөгөөд цаашид ч энэ харилцаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж байна. 2000 оны 10-р сард Ерөнхийлөгч Владимир Путин Энэтхэгт хийсэн айлчлалын үеэр “Энэтхэг-Оросын стратегийн түншлэлийн тухай тунхаглал”-д гарын үсэг зурснаар хоёр талын харилцааг хөгжүүлэх томоохон алхам болсон. Түүнээс хойш улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан технологи, соёл урлаг зэрэг өргөн хүрээг хамарсан хамтын ажиллагаа ихээхэн өргөжин тэлж байна. 2010 оны 12-р сард Ерөнхийлөгч Владимир Путины айлчлалын үеэр Стратегийн түншлэлийн харилцааг “Онцгой бөгөөд давуу эрхтэй стратегийн түншлэл” болгон өргөжүүлсэн нь хоёр орны харилцаа улам гүнзгийрч байгааг илтгэж байна.

Орос Улс нь Энэтхэгийн найдвартай түнш, тэр тусмаа батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны гол харилцагч гэж үзсээр ирсэн. Энэтхэг Улс 2009-2018 онд дэлхийн зэвсгийн импортын орнуудаас 9.5 хувиар дэлхийн хоёр дахь том зэвсгийн импортлогч орон болсон. Энэ нь дотоодын үйлдвэрлэлийн чадавхыг анхаарч, батлан хамгаалахын хэрэгцээнд импортын хараат байдлыг бууруулахын чухлыг харуулсан. Энэтхэгийн зэвсгийн импорт 2014-2018 болон 2019-2023 оны хооронд 4.7 хувиар өсөж, 2019-23 онд нийт зэвсгийн импортын 9.8 хувийг эзэлж дэлхийн хамгийн том зэвсэг импортлогч болсон. Орос Энэтхэгийн гол нийлүүлэгч хэвээр байгаа ч Энэтхэгийн зэвсгийн импортод эзлэх хувь 2009-2013 онд 76 хувь байсан бол 2014-2018 онд 58 хувь болж, 2019-2023 онд 36 хувь болж буурчээ. Сүүлийн

<sup>20</sup> Gahatraj, Changes of indian foreign policy since the breakdown of erstwhile ussr. Retrieved from Indian Institute of Legal Studies: [chrome-extension://efaidnbmninnibpcapjpcglclefindmkaj/https://www.iilsindia.com/study-material/499986\\_1609693269.pdf](chrome-extension://efaidnbmninnibpcapjpcglclefindmkaj/https://www.iilsindia.com/study-material/499986_1609693269.pdf)



**График.1** Энэтхэгийн газрын тосны импорт, улсуудар, 2024 оны 6 дугаар сарын байдлаар

Эх сурвалж: <https://www.moneycontrol.com/>

жилүүдэд Энэтхэг Улс, Франц, АНУ болон дотоод дахь зэвсгийн үйлдвэрээс гол зэвсгийн хэрэгцээгээ хангахыг эрэлхийлэх болжээ.<sup>21</sup>

Орос Украиныг эзлэн түрэмгийлснээс хойш барууны орнууд Оросын эсрэг хариу арга хэмжээ авч, тусгаарлах болсон. Гэсэн ч Энэтхэгийн Оростой харилцах харилцаанд ялангуяа эрчим хүчний импортод ашигтайгаар эргэсэн. Энэтхэг Улс тус улсаас нефтийн импортоо нэмэгдүүлж, Оросын түүхий нефтийн хамгийн том худалдан авагчдын нэг болжээ. Орос-Украины дайн эхлэхээс өмнө Энэтхэгийн түүхий нефтийн нийт импортын хоёр хүрэхгүй хувийг Орос эзэлж байсан бол 2024 оны 6 дугаар сарын байдлаар энэ

тоо нэмэгдэж 40 гаруй хувийг эзлэх болсон байна.<sup>22</sup> Энэтхэгийн Оросоос импортолсон газрын тосны хэмжээ 2021-22 онд 2.5 тэрбум ам.доллараас бага байсан бол 2022-23 онд 31 тэрбум ам.доллар давсан байна. Энэ нь бараг 13 дахин өссөн үзүүлэлттэй байгаа юм. Энэ байдал цаашид ч улам нэмэгдэж, 2023-24 оны санхүүгийн жилд Энэтхэгийн худалдан авалт 140 тэрбум ам.доллар болж, дайны өмнөх үеийнхээс 56 дахин нэмэгджээ.<sup>23</sup>

Энэтхэгийн Ерөнхий сайд Н.Моди, ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин нар 2023 оны 1 дүгээр сард утсаар ярьж, Энэтхэгийн Гадаад хэргийн сайд С.Жайшанкар 2023 оны сүүлээр Москвад айлчлал хийсэн зэрэг явдал

<sup>21</sup> Trends in International Arms Transfers 2023, Stockholm International Peace Research Institute, March 2024 [https://www.sipri.org/sites/default/files/2024-03/fs\\_2403\\_at\\_2023.pdf](https://www.sipri.org/sites/default/files/2024-03/fs_2403_at_2023.pdf)

<sup>22</sup> Dr Chietgij Bajpae, India-Russia relations, Chatam House, 17 October 2024 <https://www.chathamhouse.org/2024/10/india-russia-relations>

<sup>23</sup> Raymond E. Vickery Jr. and Tom Cutler, Oil for India, The National Bureau of Asian Research, 3 September, 2024, <https://www.nbr.org/publication/oil-for-india/>

нь хоёр орны харилцаа олон улсын харилцааны нөхцөл байдал таагүй байгаа энэ үед ч хэвийн үргэлжилж байгааг илэрхийлж байна. 2024 оны 7 дугаар сарын 9-нд Энэтхэгийн Ерөнхий сайд Н.Моди (N.Modi) ОХУ-д хийсэн хоёр өдрийн айлчлалаа өндөрлөж, Энэтхэг-Оросын дээд хэмжээний XXII уулзалтын хүрээнд Ерөнхийлөгч Владимир Путинтай өргөн хүрээтэй хэлэлцээ хийсэн. Энэ нь Н.Модигийн гурав дахь бүрэн эрхийн хугацаа эхэлснээс хойш Орост хийж буй анхны айлчлал төдийгүй 2022 оны 2 дугаар сард Орос-Украины мөргөлдөөн хурцадсанаас хойших анхны айлчлал<sup>24</sup> болсон юм.

Энэтхэг-Оросын хоёр талын харилцаа 75 гаруй жилийн турш бат бөх, тогтвортой байж, орчин үеийн дэлхийн хамгийн тогтвортой томоохон түншлэлийн харилцаатай орны нэг гэдгээрээ онцлог юм. Хоёр улс олон туйлт дэлхийн дэг журмыг тууштай баримталдаг бөгөөд хамтын ажиллагаа нь цэрэг зэвсгийн, цөмийн болон сансар огторгуйн хамтын ажиллагаа зэрэг уламжлалт салбараас өргөжин тэлж олон талт хамтын ажиллагааны механизмууд болох НҮБ, БРИКС, ШХАБ мөн G-20-ын хүрээнд хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна. Олон улсад өрнөж буй асуудлыг үл харгалзан Энэтхэг улс Оростой харилцах уламжлалт найрсаг харилцаагаа тасралтгүй хөгжүүлж байна гэж тус хоёр улсын харилцаанаас дүгнэж болохоор байна.

### Зүүн Азийн орнууд руу чиглэсэн

бодлого<sup>25</sup>: Энэтхэг Улсын хувьд ЗӨА-ийн бүс нутаг нь хэзээнээс чухал бүс нутаг байсаар ирсэн. Үүнийг өмнөх сайдуудын хэрэгжүүлж байсан бодлого шийдвэрүүдээс ч харагддаг. Ерөнхий сайд Нарамсиха Раогийн үеэс ЗӨА-ийн бүс нутгийн орнуудтай харилцах харилцаагаа улам бэхжүүлэх үүднээс “Зүүнийг харах бодлого” (Look East Policy) 1992 онд хэрэгжүүлж эхэлсэн. 2014 оноос Н.Моди тус бодлогыг илүү боловсронгуй болгож, Зүүн рүү чиглэсэн бодлого буюу Act East Policy болгон өөрчилсөн. Act East Policy-ийн (АЕР) гол цөм нь АСЕАН руу чиглэсэн бодлого юм. Н.Моди 2014 оны 11 дүгээр сард жил бүр зохион байгуулагддаг АСЕАН-ы орнуудын дээд хэмжээний уулзалтын үеэр эл бодлогын өөрчлөлтөө зарлаж, Азийн хөршүүдтэйгээ идэвхтэй хамтран ажиллахаа онцолсон төдийгүй хурдацтай хөгжиж буй Энэтхэг болон АСЕАН нь бие биеийнхээ агуу түнш байж чадна<sup>26</sup> гэж хэлжээ. Энэтхэгийн АСЕАН-тай харилцах харилцаа нь эдийн засгийн хамтын ажиллагаанаас гадна аюулгүй байдал, улс төр, стратеги, батлан хамгаалах, терроризмын эсрэг хамтын ажиллагааг хамарсан олон талт хамтын ажиллагааны хүрээг хамарч байна. Түүнчлэн АСЕАН-ы орнуудтай ISIS-ын хамтын ажиллагаа нэмэгдэж байгаатай холбогдуулан терроризмын эсрэг тусламжид онцгой анхаарал хандуулж байна. Энэхүү зорилтод хүрэхийн тулд АСЕАН-ы орнуудтай батлан хамгаалах түншлэлийн харилцаагаа ахиулж, АЕР бодлогын хүрээнд хамрах хүрээгээ ихээхэн өргөжүүлсэн бөгөөд үүнд

<sup>24</sup> Spenser A. Warren, Sumit Ganguly, India–Russia Relations after Ukraine, *Asian Survey*, 2022

<sup>25</sup> Англиар Act East Policy

<sup>26</sup> Мөн тэнд, р-2

АСЕАН-ы орнуудаас гадна Номхон далайн арлын орнууд, Өмнөд Солонгос, Япон, Австрали, Монгол<sup>27</sup> зэрэг улсууд багтах болсон.

Act East Policy нь дараах гурван онцлогтой.

Нэгдүгээрт, Act East Policy нь Зүүн Өмнөд Азийн АСЕАН-ны 10 орон, Зүүн Хойд Азийн орнууд (БНХАУ, Япон, хоёр Солонгос, Тайван, Монгол) болон Номхон далайн орнууд (Австрали, Шинэ Зеланд, Фижи)-ыг хамарна. LEP-ээс ялгаатай нь АЕР Дорнодын алслагдсан хөршүүдтэйгээ харилцах харилцаандаа их анхаарал хандуулдаг.

Хоёрдугаарт, Манмохан Сингхийн удирдлага дор байсан өмнөх засгийн газар гадаадын тусламж, хөрөнгө оруулалт, зүүн хөршүүдтэйгээ худалдаа, эдийн засгийн харилцааг нэмэгдүүлэхийг эрмэлзэж байсан бол Н.Модигийн удирдлага доорх АЕР илүү идэвхтэй, тууштай арга барилыг баримтлах болсон нь Япон, Өмнөд Солонгос, Хятад зэрэг зүүн хөршүүдээс тусламж, хөрөнгө оруулалт, технологи, стратегийн аж үйлдвэрийн хамтын ажиллагааны талаар илүү хүчтэй хүсэлт, шаардлагыг тавьсан юм. АЕР нь эдгээр улс тус бүрд тодорхой зорилт, стратегийг тогтоож, хамтын ажиллагаа, эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг тодорхойлсон. Энэтхэгийн өсөн нэмэгдэж буй эдийн засгийн нөлөөг эдгээр улсуудтай харилцахдаа хөшүүрэг болгож, Энэтхэгийн хөгжлийн замыг түргэсгэхийн тулд бүс нутгийн гол тоглогчидтой илүү хүчтэй түншлэлийг

бий болгохыг зорьсон.

Гуравдугаарт, АЕР нь Энэтхэгт улс төр, аюулгүй байдлын үүднээс үндэсний ашиг сонирхлоо өргөжүүлэх боломжийг хангасан. АЕР-ийн хүрээнд Энэтхэг Улс дорно дахины орнуудтай стратегийн түншлэл, эвслийн харилцааг бэхжүүлж, олон талт зохицуулалтын механизмуудыг хүлээн зөвшөөрсөн. Үүнд АНУ, Зүүн Өмнөд болон Зүүн Хойд Ази дахь холбоотнуудтайгаа цэргийн хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх зэрэг орно. Энэтхэгийн тэнгисийн цэргийн хүчнийг Ази-Номхон далай эсвэл Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн орнуудад байршуулах, хоёр талт харилцаанд айлчлалын тоо өссөн. Орос зэрэг уламжлалт түншүүдээс гадна Дорнодын орнуудтай улс төр, цэргийн олон талт хамтын ажиллагаа явуулах хүсэл эрмэлзлээ илэрхийлэх боломжийг олгосон. Энэтхэг Улс бүс нутгийн болон дэлхийн хууль тогтоох үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, ашиг сонирхол, хүсэл эрмэлзлээ илүү сайн тусгахын тулд олон улсын хэм хэмжээ, институцийг бүрдүүлэхийг эрмэлзэж байна.

ЗӨА болон бусад Азийн орнууд эдийн засаг, стратегийн ашиг сонирхлын үүднээс Энэтхэгтэй харилцах харилцаандаа таатай ханддаг ч аюулгүй байдал болон бусад ашиг сонирхлын үүднээс бүс нутагтаа төдийгүй олон улсын харилцааны гол тоглогч болох Хятад Улстай харилцах харилцаандаа илүү анхаарч байсан. Гэсэн ч сүүлийн үед Хятадын давамгайлсан байдал, ноёрхогч их

<sup>27</sup> Rai, Ritesh Kumar, Emerging Dynamics in India-Mongolia Relations, International Journal of Research and Analytical Reviews, 2016, p-6

гүрний санаархал нь Өмнөд Хятадын тэнгисийн асуудлаар хөрш орнуудтай зөрчил үүсгэх болов. Азийн бусад улс орнууд Хятадаас тулгарч буй аюулгүй байдлын сорилтыг даван туулахын тулд өөр хоорондоо түншлэлийн харилцаа тогтоож, харилцаагаа бэхжүүлэх, интеграцичлалд нэгдэн орох шаардлага

бий болсон. Энэтхэг Улс Ази тивийн хоёр дахь том газар нутаг, дэлхийн хамгийн их хүн амтай улс, Хятадтай хиллэдэг хөрш улсын хувьд бүс нутаг дахь орнуудтайгаа харилцах харилцаанд чухал тоглогчийн нэг<sup>28</sup> зайлшгүй мөн гэж үздэг.

### Хоёр. Нарендра Модигийн гадаад бодлого дахь Монгол Улс

Монгол Улс нь Энэтхэгийн Ази ялангуяа Зүүн Хойд Ази дахь стратегид чухал байр суурь эзэлдэг. 2009 онд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оюун санааны хөрш улс хэмээн чухалчлан үздэгийн хувьд анхны гадаад айлчлалаа Энэтхэгээс буюу Шинэ Дели хотоос эхэлсэн. Тус айлчлалын үеэр манай хоёр улс харилцаагаа “Иж бүрэн түншлэл”-ийн хэмжээнд хүргэн, өргөтгөн хөгжүүлэхээр санал нэгдэж, хамтарсан тунхаглал гаргав. Монгол Улс гуравдагч хөршийн бодлогын хүрээнд Энэтхэгт анхаарал хандуулах болсноор хоёр тал геостратегийн ашиг сонирхлоо тодорхойлж эхэлсэн.<sup>29</sup> Хоёр тал цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах тухай, Монголын уран олборлолтыг хөгжүүлэхэд хамтран ажиллах тухай санамж бичгүүдийг байгуулсан. Энэтхэгийн байгалийн баялгийн хэрэгцээ импортоор авах сонирхол өсөн нэмэгдэхийн хэрээр Монгол Улс урт хугацаандаа эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, түнш байх сонирхол нь өсөн нэмэгдэх хандлагатай

гэж судлаач Ш.К.Сони үзжээ<sup>30</sup>.

Монгол Улс Гадаад бодлогын үзэл баримтлалаа 2011 онд шинэчлэн баталсан. Гадаад бодлогын үзэл баримтлалын 14.2-д АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “Туравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх хэмээн тусгажээ. 1994 оны Гадаад бодлогын үзэл баримтлалтай харьцуулахад БНЭУ-ыг “Туравдагч хөрш” хэмээн тодорхойлж, тус улстай харилцах харилцаагаа хоёр хөршийн дараа орох түвшинд авч үзэх болсноороо онцлог юм. 2011 оны 7 дугаар сард БНЭУ-ын Ерөнхийлөгч Пратибха Патил Монголд айлчлахдаа “Туравдагч хөршийн бодлогын үзэл баримтлал нь манай хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаанд мэдэгдэхүйц үр нөлөөг бий болгон нэмэгдүүлж байгаа гэж хэлжээ.<sup>31</sup>

Монгол Улс Энэтхэгтэй харилцах харилцааг чухалд тооцож гуравдагч хөршийн хүрээнд харах болсон нь Энэтхэг-Монголын харилцаа нь зөвхөн

<sup>28</sup> Panagariya Arvind, Why northeast and southeast Asia must deepen their engagement with India, *Asia and the Global Economy*, 2022, p-4-5

<sup>29</sup> Sharad K.Soni, The ‘Third Neighbour’ Approach of Mongolia’s Diplomacy of External Relations: Effects on Relations between India and Mongolia, *Sage Journal*, 2015, p-37

<sup>30</sup> Мөн тэнд

<sup>31</sup> Мөн тэнд

буддын шашин, эртний хэлхээ холбоонд тулгуурладаг гэх ойлголтыг давж өргөжиж байна. Монгол Улс Энэтхэгтэй ойр байснаар гадаад ертөнцийг харах цонх нь болох төдийгүй Хятадтай харилцах харилцааг тэнцвэржүүлэгч хүчин зүйл гэж судлаач Ш.К.Сони үзсэн байна. Энэтхэг Улс тэдэнд эерэг нөлөө үзүүлж буйг монголчууд хүлээн зөвшөөрч, хоёр орны соёлын бат бөх харилцааг стратегийн түншлэлийн харилцаанд хүргэн хөгжүүлээд байна.

Монгол, Энэтхэг хоёр улс төрийн харилцаа давамгайлсан, уламжлалт найрсаг харилцаатай байсаар ирсэн. 1990 оноос хойш ардчилал, нийгэм эдийн засгийн хөгжил, шинжлэх ухааны дэвшилд хүрэх зэрэг нийтлэг ашиг сонирхол нь хоёр талын харилцаанд шинэ түлхэц өгсөн.<sup>32</sup> Энэтхэг Монголыг өргөтгөсөн хөршийн бодлогын хүрээнд авч үздэг байсан бол Н.Модигийн үеэс “Act East Policy” бодлогын хүрээнд авч үзэх болсон. Зарим судлаачдын үзсэнээр энэхүү бодлогын гол үзэл санаа нь ЗӨА-ийн улс орнуудтай эдийн засаг, стратегийн өргөн харилцааг хөгжүүлэх, бүс нутгийн хүчирхэг гүрний байр сууриа бэхжүүлэх, БНХАУ-ын Ази дахь нөлөөллийг сааруулах юм. Гэсэн ч энэ бодлого нь ЗХА-ийн улсуудыг мөн багтаах<sup>33</sup> бөгөөд Монгол Улсыг ихэд чухалд тооцдог нь дараах хэд хэдэн онцлогтой.

*1. Монгол Улс эрдэс баялгийн арвин нөөцтэй. Орос,*

*Хятадтай хиллэдэг геополитик, геостратегийн хувьд чухал ач холбогдолтой бус нутаг мөн. 2011 оноос хойш ашигт малтмалын салбарт өсөлт бий болж, уран, алт, нүүрс, зэсийн арвин нөөцтэй байгалийн баялгаараа Монгол Улс дэлхийд эхний 10-т багтсанаар дэлхийн улс орнуудын анхаарлыг татсан. Японы судлаач Маскүда Сарпи Шиотани гийн үзэж буйгаар эдгээр асар их байгалийн баялгийн үр ашигтай менежмент дутмаг байгаа нь Монголыг эмзэг байдалд оруулж байгаа бөгөөд Энэтхэг Улс Монголын хөгжлийг бүхий л салбарт дэмжихээр тууштай хамтран ажиллана,<sup>34</sup>*

*2. Эртний харилцаатай “Оюун санааны хөрш”. Ариун гангын орноос гаралтай буддын шашин нүүдэлчдийн байгуулсан анхны төрт улс Хүннүгийн үед Төв Азид торгоны замаар дамжин орж ирж байсан түүхтэй. 2014 онд Н.Моди Ерөнхий сайд болсноос жилийн дараа анхны бүрэн эрхт айлчлалынхаа хүрээнд Монгол, Энэтхэгийн хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойг тохиолдуулан 2015 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Монголд айлчилсан. (Ерөнхий сайд Н.Моди айлчлалаа Монголын бурхан шашны төв Гандантэгчэнлин хийдээс эхлүүлж, Хамба лам*

<sup>32</sup> Rai, Ritesh Kumar, Emerging Dynamics in India-Mongolia Relations, International Journal of Research and Analytical Reviews, 2016, p-4-6

<sup>33</sup> Vaishali Krishna, “India and its Extended Neighbourhood: Engagements with Mongolia and Central Asia”, Mongolian Journal of International affairs Vol.21, 2020

<sup>34</sup> Shiotani, M. S. (2019). India’s Act East Policy: Japan and Mongolia. 國際文化= Intercultural studies, 1, 36

Чойжамцад бодь модны зулзаган нахиа бэлэглэсэн) Тус айлчлалын үеэр Н.Моди “Энэтхэг, Монголын хоорондох харилцаа газарзүйн саадыг давж, түүхийн он дарааллын олон зуун жилийг ардаа орхижээ. Монголчууд маань энэтхэгчүүд биднийг өнөөдөр “Оюун санааны хөрш”-өө гэж нэрлэдэг. Үүнээс илүү хөршийн өндөр харилцааны хэлбэр гэж үгүй, энэ үнэт харилцааг бид гүнээ хүндэтгэдэг. Бидний хамтын идэвх чармайлт нь эдийн засгийн түншлэл, энхийн зорилгоор цөмийн энергийг ашиглах тухай гэрээ байгуулах, аюулгүйн хамтын ажиллагаа тогтоох зэрэг төрөл бүрийн салбарт өргөжин бэхжиж байна. Энэтхэг, Монгол хоёр орны хооронд тогтсон зүрх сэтгэл, оюун санааны харилцаа нь хөрш зэргэлдээ орших, эсвэл худалдааны хэлхээ холбооноос ч илүү урт удаан оршин тогтнодог гүүр байж чадна гэдгийг харууллаа. Гэхдээ бид ирээдүйд эдийн засгийн хүчтэй түншлэлийг тогтоохын төлөө бас итгэл төгс байна хэмээн хоёр орны харилцааг ихэд өндрөөр үнэлж, цаашид түншлэлийн харилцаагаа үргэлжлүүлэн хөгжүүлнэ гэж тодотгосон байна.”<sup>35</sup>

3. *Ази дахь Хятадын нөлөөллийг бууруулах.* Монгол Улс Энэтхэгийн ЗХА-ийн талаар баримтлах бодлого, Төв Азийн

орнуудад баримтлах бодлогод чухал байр суурийг эзэлдэг. Сүүлийн 20 жилийн хугацаанд Хятад Улс Монголын уул уурхайн салбар, дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөгжилд хөрөнгө оруулах болсноор БНХАУ-ын хүч нөлөө улам нэмэгдсэн. Манай улсын гадаад худалдааны экспорт, импортын ихэнх хувийг БНХАУ эзэлдэг. 2014 онд Монгол Улс БНХАУ-тай стратегийн түншлэлийн харилцаагаа нэг шат ахиулж “Иж бүрэн стратегийн түншлэл”-ийн харилцаатай болсноор хоёр талын харилцаа улам өргөжин хөгжсөн.

Ерөнхий сайд Н.Модигийн айлчлалын үеэр Монгол Улс, БНЭУ-ын хооронд 1994 онд байгуулсан Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээний үндсэн үзэл санаа болон бусад хоёр талт баримт бичгүүдэд суурилан Монгол, Энэтхэгийн харилцаа “Стратегийн түншлэл”-ийн түвшинд хүрсэн. Энэ хүрээнд хоёр тал нийт 13 баримт бичигт гарын үсэг зурсан байдаг.<sup>36</sup> Тухайлбал, кибер аюулгүй байдлын сургалтын төв байгуулах тухай, хил хамгаалалт, хилийн дэглэм сахиулах, хилийн хяналтын чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хоорондын хамтын ажиллагааны тухай гэсэн баглан хамгаалах салбартай холбоотой гурван баримт бичиг багтсан.

<sup>35</sup> Зууны мэдээ, Энэтхэг ба Монгол: Оюун санааны хөршүүд, хөгжил дэвшлийн түншүүд, 2015 оны 5.15, ikon.mn: <https://ikon.mn/n/gv5->

<sup>36</sup> Амармэнд.А, Монгол, Энэтхэг хоёрын ашиг сонирхол нийлэх цэг. (2015 оны 5 20). gogo.mn Засгийн газрын мэдээ: <https://gogo.mn/r/gxy25>

Айлчлалын үр дүнд манай хоёр улсын харилцаа шинэ шатанд гарсан бөгөөд Энэтхэгийн оролцоог Зүүн Ази, ЗХА-д мэдрүүлэх стратегийн чухал алхам болсон гэж судлаачид үзэж байна. Энэхүү айлчлал нь хоёр орны аль хэдийн бий болсон хоёр талын харилцааны геостратегийн хүрээг өөрчилсөн юм. Талууд айлчлалын үеэр хамтарсан мэдэгдэл гаргаж, Ерөнхий сайд Н.Моди нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл олгохоор болж, энэхүү зээлээрээ Монгол Улсын эдийн засаг, эрчим хүчний тусгаар тогтнолыг баталгаажуулах анхны газрын тос боловсруулах үйлдвэр барихаар тохиролцжээ. Энэтхэгийн тал түүхий эдийн тээвэрлэлтийн арга хэрэгслийг Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт дуусгавар болохоос өмнө эцэслэсэн байх нь чухал болохыг дахин онцлов. Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан Техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсаны дагуу тус төслийг амжилттай хэрэгжүүлэхэд түүхий эд тээвэрлэлтийн арга хэрэгслийг эцэслэн шийдвэрлэж ашиглалтад оруулсан байх нь нэн чухал гэдэгт Монголын тал санал нэгдэв. Талууд энэхүү төсөл нь Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдал болон эдийн засгийн өсөлтийг хангахад томоохон хувь нэмэр оруулна гэдэгт санал нэгтэй байгаа юм. Бүтээн байгуулалтыг дөрвөн хэсэгт хуваан хэрэгжүүлж байгаа бөгөөд 2026 онд бүтээн байгуулалтын ажил дуусаж 2027 онд ашиглалтад орох

тухай “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг мэдэгджээ.<sup>37</sup>

Энэтхэг, Монгол хоёр улс сүүлийн жилүүдэд аюулгүй байдал, батлан хамгаалах, хилийн аюулгүй байдлын чиглэлээр хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна. Энэтхэг-Монголын аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа ахицтай хөгжиж байгаа бөгөөд юуны өмнө хоёр орны хилийн харуулын чадавхыг бэхжүүлэхэд анхаарч байна. Үүнд Энэтхэг Улсын Хилийн хамгаалалтын алба болон Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газар, хоёр улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хоорондын санаачилга багтаж байна. Энэтхэгээс манай улстай байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийн багагүй хувь нь Батлан хамгаалах салбар руу чиглэж байсан. Ерөнхийлөгч Пратибха Патилын 2011 онд манай улсад хийсэн айлчлалынхаа үеэр талууд батлан хамгаалах салбарт хамтран ажиллах гэрээг үзэглэж, “Нүүдэлчин Заан” нэртэй цэргийн хамтарсан сургалт, дадлагыг жил бүр зохион байгуулах болсон. Мөн 2003 оноос эхлэн манай улсаас жил бүр зохион байгуулж буй “Хааны эрэлд” энхийг дэмжих олон улсын цэргийн сургуулилтад ч Энэтхэгийн цэргийн биеэ бүрэлдэхүүн идэвхтэй оролцдог. Иймд хамтын ажиллагаа цаашид ч үргэлжлэх төлөвтэй байгааг хоёр улсын дээд удирдагчид нотолсон.

<sup>37</sup> Эрдэнэбулган. (2023, 9 11). Л.Оюун-Эрдэнэ: Газрын тосны үйлдвэр бол Монгол-Энэтхэгийн найрамдалт харилцааны бэлгэдэл, МОНЦАМЭ: <https://www.montsame.mn/en/read/326375>



## Дүгнэлт

Нэгт, Н.Моди Ерөнхий сайд болсноор гадаад бодлогодоо томоохон өөрчлөлтийг хийсэн нь Look east policy-г Act East Policy болгон өөрчилсөн явдал юм. Энэхүү бодлогын хүрээнд Энэтхэгийн гадаад бодлого АСЕАН, Ази-Номхон далай, Энэтхэг-Номхон далайн бүс нутаг, ЗХА-ийн бүс нутаг руу илүүтэй төвлөрч, улс төр, аюулгүй байдал, эдийн засгийн харилцааны ашиг сонирхол дээр тулгуурлан цар хүрээ, агуулгаараа хөгжин, тэлж байна. БНЭУ улс ЗХА-ийн бүс нутгийн хүчирхэг, хөгжингүй орнуудтай эдийн засаг, батлан хамгаалахын салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх ашиг сонирхолтой байгаа нь харилцан ашигтай, хамтын ажиллагааг бий болгон хөгжүүлснээр бүс нутаг, олон улс дахь хүчний тэнцвэрийг бий болгохыг эрмэлзэж байна. Нөгөөтээгүүр түүхийн урт хугацааны явцад Энэтхэгийн аюулгүй байдлын гол сорилт байсаар ирсэн Хятадтай энхийн дипломат харилцааг эрхэмлэж, эдийн засгийн салбарт хамтын ажиллагааг тууштай хөгжүүлж байгаа боловч, тус улс хурдацтай хөгжин, бүс нутаг, дэлхийд ноёрхлоо бий болгож буй нь Энэтхэгийн аюулгүй байдлын асуудлыг хөндсөн хэвээр байна. Тиймээс ч Энэтхэгийн гадаад бодлого нь угтаа өөрийн үндэсний ашиг сонирхлыг чухалчлан, бүс нутагт өсөн нэмэгдэж буй Хятадын нөлөөний эсрэг тэнцвэртэй гадаад бодлого явуулахыг эрмэлзэж байна. Энэтхэг улс нь хүчний тэнцвэрийн онол болон реализмын онолын хүрээнд дэлхийн системд чухал байр суурьтай. Энэ нь Энэтхэгийг олон улсын харилцааны тогтвортой байдалд онцгой нөлөөтэй оролцогч болгож байгаа юм. Энэтхэгийн гадаад бодлого нь өөрийн аюулгүй байдлыг хангах, бүс нутагтаа

тэнцвэржүүлэгч хүч болох, мөн дэлхийн хэмжээний тоглогчийн байр сууриа бэхжүүлэхэд чиглэгдэж байна хэмээн дүгнэлээ.

Хоёрт, Монгол, Энэтхэг нь эртний түүхэн хэлхээ холбоо, хоёр орны ард түмний дундах шашин, соёлын харилцааны нийтлэг итгэл үнэмшилд тулгуурлан харилцаж ирсэн нь өдгөө гуравдагч хөршийн бодлого, стратегийн түншлэлийн хүрээнд илүү өргөжин, хөгжиж байна. Энэтхэгийн Ерөнхий сайдуудаас Н.Моди анх Монголд айлчилж, хоёр орны хооронд стратегийн түншлэлийн харилцааг тогтоосон нь 2014 оноос Энэтхэгийн Монголд хандах хандлага, бодлого өөрчлөгдөж, ач холбогдол өсөн нэмэгдсэн гэж үзэж байна. Монгол Улс бол БНХАУ, ОХУ-ын дунд орших байгалийн асар их баялагтай геополитик, геостратегийн хувьд чухал ач холбогдолтой бүс нутаг учир сүүлийн үед Энэтхэгийн ашиг сонирхлын цэг болж байна. Энэтхэг Улс нь манай хоёр орны эртнээс одоог хүртэл үргэлжилсээр ирсэн найрсаг, таатай харилцаан дээр тулгуурлан Монголтой харилцаагаа хөгжүүлж, хөнгөлөлттэй зээл, тусламж үзүүлэн, дэмжин харилцаж байгаа нь цаагуураа Хятад руу чиглэсэн бодлого явуулж байгаагийн нэг арга хэлбэр болж байна гэж дүгнэлээ. Ингэснээр Монгол-Энэтхэгийн харилцаа бол хоёр талын нийтлэг ашиг сонирхлын үндсэн дээр хөгжин бэхжиж, улс төр, аюулгүй байдлын үүднээс БНХАУ-ын нөлөөллийг багасгаж, бусад орнуудтай хоёр талт, бүс нутаг, олон талт идэвхтэй харилцаа, гадаад бодлогыг явуулснаараа Энэтхэг Улс олон улсад өөрийн эерэг дүр төрхийг бүтээн, хүчээ нэмэгдүүлж байна хэмээн үзлээ.

Ном зүй / References:

*Монгол хэл дээрх эх сурвалж:*

1. Алтанцэцэг.Н, “Даяаршлын үеийн Энэтхэгийн гадаад бодлогын онцлог, шинэчлэл ба Монгол Улсын байр суурь”, *Олон улсын харилцаа (тусгай дугаар)*, 23(2), 5-11, 2021 он
2. Алтанцэцэг.Н, *Хятад, Монгол, Энэтхэг гадаад бодлогын солбилцол ба онцлог, эрдэм шинжилгээний төсөл, өгүүлэл, илтгэлүүд*, Улаанбаатар, 2021 он, 632 тал
4. Амармэнд.А, *Монгол, Энэтхэг хоёрын ашиг сонирхол нийлэх цэг*. (2015 оны 5 20). gogo.mn Засгийн газрын мэдээ: <https://gogo.mn/r/gxy25>
5. Болор.Ж, *Монгол, БНЭУ дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой тохиож байна 2020.12.24*. Retrieved from Монцамэ: <https://montsame.mn/mn/read/247835>
3. Дэмбэрэл.К, *Олон улсын харилцааны онол, үйл ажиллагааны үндэс, Улаанбаатар*, 2018 он
6. Зууны мэдээ, Энэтхэг ба Монгол: Оюун санааны хөршүүд, хөгжил дэвшлийн түншүүд, 2015 оны 5. 15, ikon.mn: <https://ikon.mn/n/gv5-ээс>
7. Нямдаваа.О, *Монгол-Энэтхэгийн харилцаа хамтын ажиллагааны нэгэн жаран /1955-2015/*. Улаанбаатар, 2015 он
8. Эрдэнэбулган, *Л.Оюун-Эрдэнэ, Газрын тосны үйлдвэр бол Монгол-Энэтхэгийн найрамдалт харилцааны бэлгэдэл*, МОНЦАМЭ, 2023 он. <https://www.montsame.mn/en/read/326375>

*Англи хэл дээрх эр сурвалж:*

9. Aditi Malhotra, Engagement, not Entanglement: India’s Relationship with the Quad, *Georgetown Journal of International Affairs*, May 1 2023, <https://gjia.georgetown.edu/2023/05/01/engagement-not-entanglement-indias-relationship-with-the-quad/>
10. Aneetta Thomas Peedikayil, Aswathy Koonampilly, Medha Bhagwat, India’s Realist Foreign Policy: Present-Day Relevance, *Extraordinary and Plenipotentiary Diplomats Analysing International Relations*, 20 October, 2020 <https://diplomatist.com/2020/10/20/indias-realist-foreign-policy-present-day-relevance/>
11. Chaulia, S. (2016). *Modi Doctrine: The Foreign Policy of India’s Prime Minister*. New Delhi: Bloomsburry Publishing.
12. Chellaney, B. (2021 оны December 4). “Deconstructing the Modi Foreign Policy.” *Hindu*,. The Hindu: <https://www.thehindu.com/opinion/lead/Deconstructing-the-Modi-foreign-policy/article62119056.ece->
13. *Evolution of India’s Foreign Policy*. (2023 оны March 29). Vajiram&Ravi Institute for IAS Examination: <https://vajiramandravi.com/quest-upsc-notes/evolution-of-indias-foreign-policy/>

14. F.Power, P. (1964 оны April). Indian Foreign Policy: The Age of Nehru. *The Review of Politics*, 257-286. <https://www.jstor.org/stable/1405752>
15. GAHATRAJ, D. (n.d.). *CHANGES OF INDIAN FOREIGN POLICY SINCE THE BREAKDOWN OF ERSTWHILE USSR*. Retrieved from Indian Institute of Legal Studies: chrome-extension://efaidnbmnnnibpcajpcgclefindmkaj/https://www.iilsindia.com/study-material/499986\_1609693269.pdf
16. Hall, I. (2015 оны February 2). Is a ‘Modi doctrine’ emerging in Indian foreign policy. *Australian Journal Of International Affairs*, 69(3), 247-252. doi:DOI: 10.1080/10357718.2014.1000263
17. Hall, I. (2019). *Modi and the Reinvention of Indian Foreign Policy*. Bristol: Bristol University Press.
18. Ian Hall, Summit Ganguly. (2022 оны October 30). Introduction: Narendra Modi and India’s foreign policy. *International Politics*, 1-8. <https://link.springer.com/article/10.1057/s41311-021-00363-8>
19. *India’s Foreign Policy: 2014-19: Landmarks, achievements and challenges ahead*. (2019 оны July 22). Ministry of External Affairs, Government of India: <https://www.mea.gov.in/distinguished-lectures-detail.htm?833>
20. Krishna, V. (2020). “India and its Extended Neighbourhood: Engagements with Mongolia and Central Asia” Vol.21, 2020. *The Mongolian Journal of International Affairs*, 21.
21. K.Soni, S. (2015). The ‘Third Neighbour’ Approach of Mongolia’s Diplomacy of External Relations: Effects on Relations between India and Mongolia. *Sage Journal*, 71(1), 37-52. doi:DOI: 10.1177/0974928414554975
22. Rai, Ritesh Kumar, Emerging Dynamics in India-Mongolia Relations, *International Journal of Research and Analytical Reviews*, 2016, p-4-6
23. Soni, S. K. (2016). Emerging Dimensions of India-Mongolia Relations. *Indian Foreign Affairs Journal*, 11(1), 51-62.
24. Soni, S. K. (2015). The ‘Third Neighbour’ Approach of Mongolia’s Diplomacy of External Relations: Effects on Relations between India and Mongolia. *India Quarterly*, 71(1), 37-52
25. Wooyeal Pak, Rajiv Kumar. (2019 оны April 30). India’s Extended “Act East” Outreach to Northeast Asia: Its Economic and Security Interactions with China, Japan, and South Korea. *The Korean Journal of International Studies*, 1-29. doi:https://doi.org/10.14731/kjis.2019.4.17.1.1

## Mongolia in the Foreign Policy of India under Narendra Modi

***Munkhzul Enkhbaatar***

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences*

*Ulaanbaatar, Mongolia*

*munkhzul\_e@mas.ac.mn*

***Abstract:*** *The victory of the Bharatiya Janata Party in the 2014 elections, replacing the long-standing government led by the Indian National Congress, drew the attention of international relations and political science scholars to how India's foreign policy would change and what direction it would take. Researchers were divided on whether India's foreign policy would undergo a significant shift or continue the course of previous administrations under the leadership of Narendra Modi. Under Modi's leadership, India's foreign policy has focused on economic diplomacy and a strong foreign policy aimed at establishing itself as a powerful nation, not only in the region but also on the global stage.*

***Keywords:*** *Narendra Modi, Indian foreign policy, interests, Mongolia, Third Neighbor Policy*

<i>The day of submission:</i>	<i>2024.10.08</i>
<i>Completion of Review:</i>	<i>2024.11.18</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2024.12.19</i>